

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 11 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 257

Улаанбаатар хот

“Ургац өгөөж” ХК-ийн хувьцааг
бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйлийг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Ургац өгөөж” ХК-ийн 146921 ширхэг нийтэд санал болгон гаргасан хувьцааг үнэт цаасны бүртгэл, Хөрөнгийн биржийн жагсаалт, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/, “Хөрөнгийн бирж” ХК /Р.Содхүү/, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын талаар олон нийтэд мэдээлж, жижиг хувьцаа эзэмшигчидтэй тооцоо хийж дуусган 2008 оны 4 дүгээр улиралд багтаан Хороонд мэдэгдэхийг “Ургац өгөөж” ХК /Д.Дүгэр/, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоолын талаар Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн албанд 10 хоногийн дотор мэдэгдэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ